





СЭЛЭНГЭ АЙМАГ  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/77

Алтанбулаг

Хичээл сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 10.4.6, 10.4.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, 11.1.8, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 17 дугаар зүйлийн 17.1.1, Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 03 дугаар сарын 26-ны А/120 дугаар тушаалын 4 дэхь заалт, Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/98 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн хичээл сургалтын үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэл түр хугацаагаар зогсоосугай.

2.Хичээл сургуулийн үйл ажиллагааг түр зогсоосон хугацаанд теле хичээлийн хуваарийг суралцагч эцэг эх, асран хамгаалагч нарт тогтмол мэдээлэх, цэцэрлэг сургуулийн гадна дотор орчинд ариутгал халдваргүйтлийг зааврын дагуу чанартай хийх, багш ажилтныг ажлын байранд цуглуулахгүй байх, сургуулийн урлаг танхим, спорт заалыг бусдад түрээсийн хэлбэрээр ашиглуулахгүй байх, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх зайны сургалтад төгсөх ангийн сурагчдыг бүрэн хамруулах, хүүхдүүдийн хөдөлгөөнийг хязгаарлах талаар эцэг эхчүүдэд зөвлөхийг 1-р цэцэрлэгийн эрхлэгч /Д.Болормаа/, 2-р цэцэрлэгийн эрхлэгч /Ж.Мөнхтуяа/, 3-р цэцэрлэгийн эрхлэгч /Д.Лхагважав/, Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Б.Эрдэнэ-Очир/ нарт тус тус үүрэг болгосугай.

3.Сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан хүүхэд хамгааллын ажилд онцгой анхаарах, тэднийг ахуйн осол, гэмтэл, эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх хариуцлагатай хөдөлгөөнт эргүүл жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга, шуурхай штабын дарга /Ү.Янжиндулам/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ